



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/124

Булган сум


“КВН лиг”-ийн урлагийн наадамд оролцох
багш, сурагчдын зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөр”-ийг батлах тухай IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Буриад улсын Улаан-Үдэ хотод зохион байгуулагдах “КВН лиг”-ийн урлагийн наадамд оролцох багш, сурагчдын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР